



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар A/267

Улаанбаатар хот

Коронавируст халдвар /КОВИД-19/-тай
иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх
чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8, 35 дугаар зүйлийн 35.2. дахь хэсэг, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх, Улсын онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-тай иргэнд үзүүлэх үндсэн тусламж, үйлчилгээний чиглэлийг нэгдүгээр, коронавируст халдвар /КОВИД-19/-тай иргэнийг хэвтүүлэн эмчлэх мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлийг хоёрдугаар, коронавируст халдвар /КОВИД-19/-тай тусгай хэрэгцээт иргэд болон тусгай чиг үүргийн албан хаагчдад чиглэсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эмнэлзүйн заавраар эрэмбэлэн ангилалтыг зөв хийж, шатлалын дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх, дүүрэг доторх болон дүүрэг хоорондын орны зохицуулалтыг хийж ерөнхий зохион байгуулалтаар ханган ажиллахыг Нийслэлийн эрүүл мэндийн газар /Б.Бямбадорж/-д үүрэг болгосугай.

3. Дэлгэсэн орны тоо, гаргасан чиглэл, зохицуулалтын дагуу хүндрэл чирэгдэлгүй тусламж, үйлчилгээ үзүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буянтогтох/, Эмнэлзүйн зөвлөх баг, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Л.Баттөр/-д тус тус даалгасугай.

5. Коронавируст халдварын голомтын ариутгал, халдварын сэргийлэлтийг хангахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн

бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Л.Энхсайхан/-т, Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/-д тус тус даалгасугай.

6. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын хэвтүүлэн эмчлэхтэй холбоотой зардлыг зохих тушаал, журмын дагуу хянаж Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/-т даалгасугай.

8. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/196- дугаар тушаалын хавсралт, А/225 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 сарын
28 өдрийн 1/257 тушаалын нэгдүгээр хавсралт

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ТАЙ ИРГЭНИЙГ ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ
ҮНДСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛ**

№	Дүүрэг	Эрчимт эмчилгээний ор	Орны тоо
БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ			
1	Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг	15	190
2	АШУУИС-ийн дотуур байр	-	392
3	АШУУИС-ийн МЯСЭ	20	152
4	Цэргийн төв эмнэлэг	6	150
5	ХӨСҮТ	5	150
6	Шиномед эмнэлэг		50
	НИЙТ	46	1084
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ			
1	СХДНЭ	30	210
2	ЭНЭҮТ- II	5	350
3	СХДЭМТ-ийн Баянхошуу салбар амбулатори	-	100
4	УГТЭ	20	50
5	Нандин ухаан	-	50
6	Гэгээн манал	-	65
	НИЙТ	55	825
ХАН-УУЛ ДҮҮРЭГ			
1	ХУДНЭ	10	150
2	ЭНЭҮТ- II	6	250
3	Жаргалант сувилал /ОБЕГ/		83
4	УГТЭ	10	30
	НИЙТ	26	513
СҮХБААТАР ДҮҮРЭГ			
1	СБДНЭ	15	180
2	СБД ЭМТ-ийн харьяа сувилал		60
3	СЗКЭ		110
4	УНТЭ	5	39
	НИЙТ	20	389
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ			
1	ТТАХНЭ	6	60
2	СЗКЭ		116
3	АӨСҮТ		35
4	УХТЭ	20	30
5	ХӨСҮТ	3	100
	НИЙТ	29	341
БАЯНГОЛ ДҮҮРЭГ			
1	БГЭМТ	6	115
2	БГЭМТ Ахмадын эмнэлэг	15	130
3	Ачтан эмнэлэг	6	140
4	УНТЭ	6	40
	НИЙТ	33	425
АЛСЛАГДСАН 3 ДҮҮРЭГ			
1	Багануур ЭМТ	5	65
2	Налайх ЭМТ	4	50
3	Багахангай ЭМТ	2	17
	НИЙТ	11	132
ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД			
1	ХӨСҮТ	12	110
2	ЭНЭҮТ- II	-	50
3	Цэргийн төв эмнэлэг	6	100
	НИЙТ	18	210
	БҮГД ДҮН	238	3969

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 сарын
28 өдрийн А/ тушаалын хоёрдугаар хавсралт

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ТАЙ ИРГЭНИЙГ ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ
МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛ**

№	Тусламж, үйлчилгээний чиглэл	Иргэний харьяалал	Хүлээн авах ЭМБ	Тайлбар
А. Эх барих, эмэгтэйчүүд, хүүхэд				
1	Төрсний дараах үеийн тусламж үйлчилгээ	Харгалзахгүй	ЭНЭҮТ II	50 ор
2	Хүнд, маш хүнд эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ	Харгалзахгүй	ЭХЭМҮТ	21 ор
3	Эх барихын тусламж, үйлчилгээ	БЗД	Амгалан амаржих газар	10 ор
4		ЧД, ХУД, БГД	Өргөө амаржих газар	10 ор
5		СХД	Хүрээ амаржих газар	4 ор
6		СХД	ХӨСҮТ төрөх тасаг	10 ор
7	Хүнд, маш хүнд хүүхдийн тусламж, үйлчилгээ	Харгалзахгүй	ЭХЭМҮТ	82 ор
Б. Мэс заслын тусламж, үйлчилгээ				
8	Яаралтай мэс засал	БЗД, СБД, БХД, НД, БНД	УХТЭ	10 ор
		Бусад дүүрэг	ХӨСҮТ	
Нийт				197 ор
В. Гемодиализийн тусламж, үйлчилгээ				
9	Гемодиализ	БГД, СБД	УНТЭ	Үйлчлүүлэгчийг дүүргийн эмнэлэг нь хүргэх, авах
		СХД, ХУД,	Цэргийн төв эмнэлэг	
		БЗД, ЧД, НД, БХД, БНД	ХӨСҮТ	
Г. Бусад тусламж, үйлчилгээ				
10	Хавдарын тусламж үйлчилгээ	Харгалзахгүй	ХСҮТ	
11	Арьсны өвчний тусламж үйлчилгээ	Харгалзахгүй	АӨСҮТ	
12	Сэтгэцийн өвчний тусламж үйлчилгээ	Харгалзахгүй	СЭМҮТ	
13	Гэмтлийн тусламж үйлчилгээ	Харгалзахгүй	ГССҮТ	
14	Бусад төрөлжсөн тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнд лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг			

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 сарын 28
өдрийн 4/... тушаалын гуравдугаар хавсралт
267

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ТАЙ ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ БОЛОН
ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АЛБАН ХААГЧДАД ЧИГЛЭСЭН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛ**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Харьяа яам	Орны тоо	Тусламж, үйлчилгээний чиглэл
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяа Сэргээн засах төв	ХНХЯ	32	Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчд
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв	ХНХЯ	120	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүүхэдтэй гэр бүл
3	ТТАХНЭ	ХЗДХЯ	60	Төрийн тусгай албан хаагч
4	Улаанбаатар ТЗНЭ	ЗТХЯ	40	Төмөр замын харьяа байгууллагуудын ажилчид
5	Цэргийн төв эмнэлэг	БХЯ	50	Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний тусгай чиг үүргийн албан хаагчид
	Нийт		302	